



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар

сарын 06 ны өдөр

Улаанбаатар

№ 97

хот

Орон нутгийн өмчийн тухай

Монгол улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрөөс нийслэл Улаанбаатар хотод эхний ээлжинд шилжүүлж байгаа 120 тэрбум 641 сая 419600 төгрөгийн үнэ бүхий нийт 504 байгууллагын эзэмшиж буй эд хөрөнгийг 1999 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн Нийслэлийн өмчид хүлээн авч, тэдгээрийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, төрийн өмчид үлдсэн болон хувьчлагдсан байгууллага, аж ахуйн нэгжийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөнд орсон байгууллагын өмчийг 3 дугаар хавсралтаар тус, тус тогтоон баталсугай.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд-ид Даалгах нь:

а) Нийслэлийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хувьчлах бодлогыг боловсруулж энэ оны 12 дугаар сард Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах

б) Хот нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн тооллогыг дүүрэг бүрээр явуулж нарийвчилсан бүртгэл гарган үнэлгээ тогтоох, өмч хүлээн авах явцад гарсан зарим өмчийг өөрчлөх, шилжүүлэх, шинээр авах асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх

в) Нийслэлийн өмчийн асуудлаар гарах бодлого, чиглэл батлагдах хүртэл Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1999 оны 9 дүгээр хуралдаанаар баталсан жагсаалтад орсон өмчөөс өөр объектыг хувьчлах, захиран зарцуулахыг түр зогсоох

г) Нийслэлийн өмчийн барилга, байгууламжийг паспортжуулж, өнгөрсөн жилүүдэд хийгдсэн үндсэн хөрөнгийн бүртгэлд ороогүй хөрөнгө оруулалтыг бүртгэх

д) Нийслэл хотод шилжин ирж байгаа зарим объектын эзэмшил, ашиглалтын байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг томилох, өөрчлөх саналаа энэ оны 11 дүгээр сард багтаан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулах

3. Энэхүү тогтоолыг 1999 оны 10 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн мөрдөж ажилласугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН ДАРГА *Ц.Баасанжав*

Ц.БААСАНЖАВ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Г.Маналжав*

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

Т.Билэгт
Т.БИЛЭГТ

Э.Гомбожав
Э.ГОМБОЖАВ

С.Мөнхжаргал
С.МӨНХЖАРГАЛ

Б.Намхайнямбуу
Б.НАМХАЙНЯМБУУ

Г.Өлзий
Г.ӨЛЗИЙ

С.Пүрэв
С.ПҮРЭВ

Ш.Түвдэндорж
Ш.ТҮВДЭНДОРЖ

